

ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДЭРГЭДЭХ ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙН САЛБАР ХОРООНЫ ГИШҮҮДИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

ГССҮТ-ийн дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны гишүүдийг нээлттэй сонгон шалгаруулах тул дараах шаардлагыг хангасан иргэд, ТББ-н төлөөлөл, ажилтнуудын төлөөллийг оролцохыг урьж байна.

Тавигдах шаардлага

- Анагаах ухаан, сувилахуйн, хууль эрх зүй, нийгмийн ухаан, сэтгэл судлалын чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн байх
- Мэргэжлээрээ 8-аас доошгүй жил ажилласан ажлын туршлагатай байх
- Ёс зүйн чиглэлээр сургалтад хамрагдсан байх
- Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй байх
- Ёс зүйн зөрчилд холбогдож байгаагүй байх
- Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага болон үйлчлүүлэгч иргэдийн төлөөлөл

Сонгон шалгаруулалтыг төвийн захирлын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн зохион байгуулна.

Хорооны бүрэлдэхүүн

- Эмчийн төлөөлөл – 2
- Сувилахуйн төлөөлөл – 1
- Хууль, эрх зүй (сэтгэл зүй) нийгмийн ухааны төлөөлөл – 1
- Олон нийтийн (ТББ, үйлчлүүлэгчийн) төлөөлөл – 1
- Дэмжих албаны төлөөлөл – 2

Нийт: 7 гишүүн

Бүрдүүлэх материал

- Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт
- Ёс зүйн сургалтад хамрагдсан гэрчилгээ, үнэмлэхийн хуулбар

Материал хүлээн авах хугацаа

Материалыг цаасан хэлбэрээр дараах хаягаар хүлээн авна.

ГССҮТ, төв байр

Хүний нөөцийн алба, 1 давхар, 150 тоот

2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 15:00 цаг хүртэл